ДУНДГОВЬ АЙМАГ
**ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 04 өдөр Дугаар А/26 Амардалай

## Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16 дах заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дах заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх заалт, 38.4 дэх заалтууд болон газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлгэрцогт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр (Цамын усны зүүн хойно)-д байршилтай иргэн Сувдаа овогтой Мөнх-Эрдэнэ (ЗЮ77102111)-ын 150000 м.кв (15 га) өвөлжөө, хаваржааны зориулалттай газрыг Доржсүрэн овогтой Бат-Очир (ЗЕ61122511)-д өмнөх эзэмшигчийн газрын зориулалт, хугацаагаар үргэлжлүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/20 тоот захирамж мөн газар эзэмших 000566692 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

3.Газар эзэмшигч иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олгон газрын ашиглалтад хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Д.Цэнд-Аюуш)-д даалгасугай.

4.Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүй зориулалтын дагуу эзэмшихийг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

ДАРГА М.БАЯРСҮХ